



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/205.

Улаанбаатар хот

Нийслэлийн Өргөө амаржих газрын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 76,265,900 (далан зураан сая хоёр зуун жаран таван мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг нийслэлийн Өргөө амаржих газар (Н.Батсайхан)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 248 нэр төрлийн 76,265,900 (далан зураан сая хоёр зуун жаран таван мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгахыг нийслэлийн Өргөө амаржих газар (Н.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний
өдрийн 0/00 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн өргөө амаржих газар

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жиж	Хэмжээ нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын Мэргэжилтн ий дүгнэлт	ЭБХХК-н шиндвар
1	Ор /өвчтөний ор/	15	ш	6	1,000,000.00	6,000,000.00	6,000,000.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах	
2	Ор /өвчтөний ор/	10	ш	24	1,100,000.00	26,400,000.00	26,400,000.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах	
3	Ор /өвчтөний ор/	11	ш	40	408,000.00	16,320,000.00	16,320,000.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах	
4	Ор /өвчтөний ор/	10	ш	13	290,000.00	3,770,000.00	3,770,000.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах	
5	Шүүгээ / өвчтөний/	54	ш	23	1,500.00	34,500.00	34,500.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах	
6	Шүүгээ / өвчтөний/	15	ш	91	128,650.00	11,707,150.00	11,707,150.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах	
7	Шүүгээ / өвчтөний/	11	ш	10	199,000.00	1,990,000.00	1,990,000.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах	
8	Ор /өвчтөний ор/	15	ш	1	364,250.00	364,250.00	364,250.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах	

9	Ор /өвчтөний ор/	10	ш	40	242,000.00	9,680,000.00	9,680,000.00	-	Ашиглах болмжгүй	Актлах	Актлах
	Тавилга, эд хогшлын дүн				248		76,265,900.00				
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						76,265,900.00				
	Үүнээс: Худалдах хөрөнгө										
	Устгах хөрөнгө						76,265,900.00				
	Татан төвлөрүүлэх хөрөнгө										
	Худалдсанаас олох орлого										
	НӨХГ-т төвлөрүүлэх /30%/										